



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 708

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах,
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Монголросцветмет" төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2 нэрийн, нийт 124,540,560.60 (нэг зуун хорин дөрвөн сая таван зуун дөчин мянга таван зуун жаран төгрөг жаран мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглаж болох хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 11,600,000.00 (арван нэгэн сая зургаан зуун мянган) төгрөгөөр шинэчлэн тогтоож, хавсралтад заасны дагуу "Хархорин АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. "Монголросцветмет" төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Б.Мөнхбат, "Хархорин АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Ж.Бадрах нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хөрөнгийг хүлээлцэх, ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох, шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3. Автотээврийн хэрэгслийг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж арга хэмжээний биелэлтийг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн
.....²⁰⁸..... дугаар тогтоолын хавсралт

**"МОНГОЛПРОСЦВЕТМЕТ" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
БҮРТГЭЛТЭЙ, ҮЛДЭХ ӨРТӨГГҮЙ ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТЫН ХУГАЦААГ СУНГАХ,
ҮНИИГ ШИНЭЧЛЭН ТОГТООЖ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ
ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Нийт балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоосон үнэ (төгрөг)	Цаашид ашиглах хугацаа (жил)
1	Хово, ZZ3257M3647B, улсын дугаар 51-34 УНО, арлын дугаар LZZ5ELNDXBA626351	2011	62,270,280.30	5,800,000.00	3
2	Хово, улсын дугаар ZZ3257N3647B, арлын дугаар LZZ5ELND5BA626354	2011	62,270,280.30	5,800,000.00	3
			124,540,560.60	11,600,000.00	
	Нийт дүн		(нэг зуун хорин дөрвөн сая таван зуун дөчин мянга таван зуун жаран төгрөг жаран мөнгө)	(арван нэгэн сая зургаан зуун мянган төгрөг)	